



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 01396

Улаанбаатар хот

**Монгол-Оросын хамтарсан 3 дугаар
Сургуулийн цайны газрын өргөтгөлийн
барилгыг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 144 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1134 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-092/1204 тоот дүгнэлт, Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн балансад бүртгэлтэй нийт 43,785,468 /дөчин гурван сая долоон зуун наян таван мянга дөрвөн зуун жаран найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий цайны газрын өргөтгөлийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургууль /Ж.Соронзон/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,171,000 /нэг сая нэг зуун далан нэгэн мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургууль /Ж.Соронзон/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001173